

“ТАМАЧИН” УУ, “ТАМГАЧИН” УУ?

Ж.Базарсүрэн

Товч утга: Монголын нууц товчоонд дуртгаж буй “Тама”, “Тамачин” хэмээх үгс нь монгол цэргийн уламжлалт нэр томъёо бөгөөд ан авын үед анчин гөрөөчдийн зээглэсэн эгнээнээс орхигдон үлдсэн газар орныг түргэвчлэн хураан авах буюу “Тамах” арга зарчим монгол цэргийн байлдах дайлах арга ухаанд тэр л агуулга, хэлбэрээрээ уламжлагдан хэрэглэгдсээр байсны илрэл нь “Тама” гэдэг тусгай замын цэргийг үүсгэн зохион байгуулсан явдал юм. Тама цэрэг нь үүрэг, зориулалтын хувьд ХХ зуунд АНУ-ын Зэвсэгт Хүчинд үүсгэн байгуулсан “Түргэн байрлуулах хүчин” болон бусад улсын ийм маягийн цэрэгтэй ижил байгаа нь тиймэрхүү шуурхай, гавишгай цэргийг ашиглах зарчмыг монголчууд анхлан санаачилж бүр XIII зуунд цэргийн хэрэгт хэрэглэж эхэлсэн болохыг харуулж байна хэмээн дүгнэх үндэстэй байна.

Түлхүүр үг: Тама, тамачин, тамачи, тамах, тан-ма, тамга, тамгачин, тусгай замын цэрэг, түргэн байрлуулах хүчин

Монголын нууц товчоо (цаашид “МНТ” гэнэ)-нд тусгагдсан Монгол цэргийн байгуулалтын түүхтэй холбоотой зүйлсийн дотор “Тама” хэмээх тусгай зориулалтын цэрэгтэй холбоотой мэдээ нийт 6 удаа гарч буй. Тухайлбал: 274 дүгээр зүйлд “...тама сууж”, “...тама суутугай” гэж 2 удаа, мөн 276 дугаар зүйлд “...тама талбиж” гэж 1 удаа гарч байна. 273, 274, 281 дүгээр зүйлд “Тамачиныг талбиж” гэж 3 удаа гарч байна.

Харин энэхүү “Тама”, “Тамачин” хэмээх үгс өнөө үед түгээмэл хэрэглэгдэхээ байсан тул тэдгээр нь чухам юу гэсэн үгс болох талаар гадаад, дотоодын судлаачид янз бүрийн таамаг дэвшүүлсээр өдийг хүрч иржээ. Тэр бүрийг үл өгүүлэн багцалваас дээрх үгсийн язгуур гарал хийгээд утга агуулгыг тодорхойлохыг эрмэлзэж буй шинжээчид эрлийн хоёр өөр чиг хандлага баримталж буй нь ажиглагдаж байна. Үүнд:

Нэгдүгээрт, гадаадын голдуу хэсэг судлаач эл үгсийг монгол бус, гадаад үг гэж үзэж тайлбарлахыг оролдсороор иржээ.

Сүүлийн үеийн нэг жишээ л гэхэд японы судлаач Мацүда Коичи, Сүдо Ёшиюки нар “Тама” гэдэг нь “Тан-ма” гэх хятад үг гэж үзээд “tan-ма гэсэн үгийн tan(探) нь “Байгаа эсэхийг судлах, шалгах” гэсэн утга, “ma”(馬) нь

морь, агт гэсэн утга бөгөөд “Tan-ma” нь “ямар нэг юм байгаа эсэхийг судалж шалгах морь” гэсэн утга болно....tan-ma нь “Сүн улсын үеийн цэрэг армийн нэр томъёо бөгөөд тэргүүн шугамд байрлаж, дайсны байдлыг тагнах морьт цэрэг гэсэн утгатай”. Монголын үеийн tan-ma-chi нь үг хэллэгийн хувьд Сүн улсын үеийн tan-ma -тай холбоотой. “Tan-ma-chi нь хятад хэлний tan-ma гэдэг үгэнд монгол хэлний ажил үүрэг гүйцэтгэгч гэсэн утга бүхий нэр үг үүсгэх “ci(-чин -ч, -гч)” дагавар залгаж бүтээсэн үг гэдэг нь ойлгомжтой¹. Монгол хэлний tan-ma-chi гэдэг хэллэг үгийн гарлын хувьд гарцаагүй хятад хэлний tan-ma-гаас гаралтай хэмээн бодно. Хятад хэлний tan-ma гэдэг үг монгол хэлэнд хэрхэн орж нутагшив гэдэг нь тодорхойгүй хэдий ч, өргөн утгаар авч үзвэл соёлын солилцооны нэг хэлбэр гэж үзэх боломжтой юм” гээд тэр санаагаа нотлох үүднээс “Сүнгийн үеийн Цэргийн хэргийн гарын авлага (Wu-jing-zong-yao “武經總要”) (Ceng Gong-liang 曾公亮-ийн зохиол)”-ийн 5 дугаар дэвтэрт “tan-ma” –гийн тухай тайлбар байна. Тэнд дурдсанаар tan-ma нь цэргийн давшилтын үед дайсны байдлыг тагнах морьт цэрэг бөгөөд гол цэргийн түрүүнд болон ар талд, баруун, зүүн гар талд 15 км зайд 2,5 км тутамд байрлаж, дайсан харагдвал туг өргөн гол цэрэгт мэдээ өгдөг, дайсан эс харагдвал тугаа буулгадаг байжээ. Монголын үед tan-ma, tan-ma-chi гэдэг хэллэг ямар утгаар хэрэглэгдэж байв гэвэл юуны өмнө “Монголын нууц товчоо”-нд “түрүүч, манлайлагч” гэсэн утгаар хэрэглэгдсэн байна. Гол хүчний түрүүнд явах цэрэг гэдэг утгаар үүрэг зорилгын хувьд Сүнгийн үеийн tan-ma -тай адил байна гэж үзэж болно” гэжээ².

Гэтэл нэгд: МНТ-нд гарч буй цэргийн хэллэг, нэр томъёоны дотор хятад нэр томъёо огт байхгүй атал гагц энэ нэр яагаад хятад болох нь ойлгомжгүй, хоёрт: хятад үгэнд монгол дагавар залгаж “эрлийз” болгосон гэдэг нь нэн эргэлзээтэй, гуравт: Сүнгийн “Тан-ма” цэрэг гол хүчнээсээ 15 км-ээс алс тасардаггүй ба цэргийн цувааны дөрвөн талд харуул, хамгаалалтын үүрэг гүйцэтгэж явдаг байж. Тэгвэл монгол цэргийн байлдааны аяны цувааны урд явдаг тийм баг цэргийг “Тама” гэдэггүй “Манлай” гэдэг ба манлайн өмнө 1-2 өдөрчийн газарт “Алгинч” болон бусад туршуул, “Суурин харуул” гэх мэт харуул, хамгаалалтыг гаргадаг. Цэргийн гол хүчний ар талд мөн тодорхой зайд “Цагдуулсан” гэж нэрлэж асан харуул хамгаалалт талбидаг. Цувааны хоёр хажуу буюу баруун, зүүн талд “Хажуугийн харуул” буюу “Баруун, зүүн гар” гэж нэрлэж асан цэргийг довтолгон халх хаалт болгодог байв.

-
1. Перс хэлээрх сурвалж Rašīd al-Dīn-ний Jāmi‘ al-Tavārikh “Судрын чуулган”-д 「探馬」 гэдэг үгийг “tamā” гэж тэмдэглэсэн. 「ci」 дагавар залгасан хэллэг байхгүй байна.
 2. Мацуда Коичи. Монголын Эзэнт гүрний үеийн Kitad нутаг дахь tan-ma-chi-гийн тухай. Чингис хааны 850 жилийн ойг тохиолдуулан хийсэн Монгол Улсын ШУА-иас зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. Улаанбаатар, 2012.

Харин “Тама” цэрэг бол бие даасан тусгай замын цэрэг бөгөөд гол хүчнээсээ 15 км төдийхөн ч бус, бүр хэдэн зуу, мянган км-ийн алс зайд тасран аялдаг, зарим газар оронд хэдэн жилээр ч суурьшин байлдааны үүрэг гүйцэтгэдэг байж. Нөгөөтэйгүүр, МНТ-нд “Тама” гэдгийг дээр дурдсанчлан гагц “түрүүч, манлайлагч” гэсэн утгаар хэрэглэсэн гэж болохгүй буюу ямархан нэг тодорхой орон зайг заагаагүй агаад гагцхүү байлдаанд бусдаас илүү хүнд хүчир үүрэг гүйцэтгэдэг цэрэг болохыг л тодорхойлон өгүүлсэн байдаг билээ.

Эл бүхнээс үзвэл “Тама”, “Тамачин” гэдэг нь Сүнгийн “Тан-ма”-тай огт хамаагүй болох нь илэрхий байна. Ийнхүү хятад гаралтай гэхээс гадна бас хятан хэлний “Та ма” буюу “Бараа бологч ноён” гэх үг гэсэн нь ч буй. Зарим нь түрэг гаралтай, эрх мэдэл ихтэй ноёныг заадаг үг³ гэх юмуу “Ляоши” хэмээх Ляо улсын түүхийн хятад сударт буй 挾马 (та ма) гэдэг үгтэй ижил “Шадарлагсад, дагагсад” гэсэн утгатай үг гэсэн таамаг ч дэвшүүлсэн байдаг⁴. Мөн Түвдийн мта-ма (mTha-ma буюу хил, хязгаар) хэмээх үгнээс үүдэлтэй бөгөөд X зууны үеэс монголчууд дам авч хэрэглэх болсон гэсэн нь ч буй. Гэвч тэр бүхэн нь “Сүнгийн” гэдэгтэй адил үндэслэлгүй таамаглал төдий зүйлс байна.

Хоёрдугаарт, монгол голдуу судлаачид тэдгээр нь монгол үгс, харин тэгэхдээ МНТ-ны хятад хадмалд алдаатай бичигдсэн үгс гэж үзсээр иржээ.

МНТ-ны хятад хадмалд “Таммачин” гэж бичээд “Ноёны нэр” гэж тэмдэглэснийг үндэслэн Элдэндэй, Ардажав нар “Энэ нь тамгач буюу эрх баригч гэсэн утгатай үг юм” гэж үзэн “Тамгачи” гэж, улмаар “Тамгачи хэмээх нь гааль татвар татварлагч, тамга хадгалагч” хэмээн тайлбарлажээ⁵. Үүнийг манай ихэнх судлаач хүлээн зөвшөөрч санал нэгдэн, бараг тэгж тогтох хандлага гарч буй нь МНТ-ны сүүлийн үеийн хэд хэдэн “Хөрвүүлэг”, “Тайлбар”-уудад “Тама” гэдгийг “Тамгач”, “Тамачин” гэдгийг “Тамгачин” гэж бичиж байгаагаас харагдаж байна⁶.

Гэтэл тэгж хөрвүүлэх нь бас л учир дутагдалтай мэт. Юун гэвээс:

Нэгэн зүйл: “Тама” гэдэг нь “Тамга хадгалагч”-ийг бус, харин юуны өмнө цэрэг, тухайлбал нэгэн төрлийн тусгай баг цэргийг өгүүлсэн ба “Тама талбих, тама суулгах” гэж тийм цэргийг юмуу тийм цэргийн захирагчийг томилохыг хэлсэн үг гэдэг нь МНТ-ноос ч ойлгомжтой байна. Тухайлбал

3. Монголын эртний цэрэг дайны толь. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2000. т.493.

4. Эрдэнэхишиг Т. Тамачи цэргийн тухай. “Цэргийн шинэчлэл” сэтгүүл. Улаанбаатар, 2012. №2. т.17

5. Элдэндэй, Ардажав. Монголын нууц товчоо. Сийрүүлэл, тайлбар. Өвөр Монголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1985. т.910.

6. Цэрэнсодном Д. Монголын нууц товчоо. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. Улаанбаатар. 2000 он. 357 дахь тал. Чоймаа Ш. Монголын нууц товчоон. Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг. УБ, 2011.

МНТ-ны 276 дугаар зүйлд

“Алгинч талбиж

Арван хуруудын химулыг (хумсыг) инү

Хууртал

Уулс мэт балгадад авируулья.

Тама талбиж

Таван хуруудын химулыг (хумсыг) ину

Тамгартал

Давтмал хатанга балгадад авируулья”⁷ хэмээн өгүүлж буй нь “Тама” хэмээгдэгсдийн гүйцэтгэж асан эн тэргүүний гол үүрэг нь “Байлдах тулалдах” үйл байсныг гэрчилж байна. Тэгвэл байлдах гол үүрэгтэй хүн бол гагцхүү цэрэг. Харин “Тамгач” бол заавал цэргийн ноён байх албагүй ба лав л одоогоор мэдэгдэж буй баримтуудаас харахад тэр үеийн цэргийн албан тушаалын дотор тийм нэр байхгүй байгаа юм. Тэгэхээр “Тама” гэдэг нь Их Монгол Улсын армийн бүрэлдэхүүнд багтаж байсан нэг төрлийн, тусгай зориулалтын цэргийн нэр гэдэг нь илэрхийлэл байна.

Нөгөө талаар дээрх өгүүлэмжид “Алгинч”, “Тама” хоёр байлдаанд дүйцүүлж болохоор ижил төстэй буюу амь дүйсэн аюултай үүрэг гүйцэтгэдэг байсныг цохон тэмдэглэсэн байна. Алгинч нь бүх цэргийн өмнө явж, дайсантай хамгийн түрүүнд тулгаран гол хүчээ иртэл амиа золин тулалдаж асан хамгийн эрсдэлтэй цэргийн баг. Тэгэхээр “Тама” цэрэг бол мөн л тийм эрсдэлтэй агаад дайсантай алгинчийн адил бие даан тулалдаж асан цэргийн баг гэдэг нь ойлгомжтой байна.

Тэгээд ч Рашид ад-Дины “Шашдирын чуулган”-д “Тама” гэдэг шилмэл, гавшгай цэрэг байсан тухай тов тодорхой өгүүлсэн байгаа нь түүний бас нэг нотолгоо. Тухайлбал тэнд “Тама цэрэг гэдэг нь онцгойд үзэгдэж, мянгат, зуутаасаа шигшигдэн, аль нэгэн газарт суурин суулгахаар илгээгддэг цэрэг юм” хэмээн тодорхойлжээ⁸.

Нөгөө талаар Монголын Юань улсын үед “Тамачи” гэдэг тусгай төрлийн цэрэг бодитойгоор оршиж байсан баримт түүхийн олон сударт тэмдэглэгдэн үлдсэн буй. МНТ-нд өгүүлсэн “Тама”-гийн гүйцэтгэж байсан гол үүрэг нь тэрхүү “Тамачи”-ийн гүйцэтгэж асан үүрэгтэй бараг ижил байгаагаас үзвэл “Тама” гэдэг нэр нь түүхэн хөгжлийн явцад ялимгүй сунжран Юань улсын үед “Тамачи” болон хувирсан гэх үндэстэй байна. Харин Рашид ад-Дины тэмдэглэлээс үзэхэд Юаниас бусад газарт “Тама” хэмээх нэр нь удтал хэвээр хадгалагдан үлдсэн байж гэж болохоор байна.

7. Шонхор. “Монголын нууц товчоо”-ны сэргээлт, Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2002, т.462.

8. Рашидаддин Фазлуллах. Шашдирын чуулган. Тэргүүн ботийн дээд дэвтэр. Орчуулагч Хатагин Го. Аким. УБ, 2013. т.55-56.

Дашрамд өгүүлэхэд Паллади Кафаров, В.Бартольд, П.Пеллиот, Ф.Кливз тэргүүтнээс эхлээд Мацуда Коичи, Дональд Островский⁹ нарыг хүртэл эл сэдвээр судалгаа шинжилгээ хийж буй бусад ихэнх судлаач “Тама”, “Тамачин” гэдэг нь цэрэг юмуу цэргийн захирагч ноёныг нэрлэж буй үг гэдэгтэй бүгд санал нэг байгаа бөгөөд гагцхүү уг үг хаанаас гаралтай гэдэг дээр л санал бодлоо уралдуулж буй гэдгийг хэлэх нь илүүц буй за.

Нэгэн зүйл: МНТ-ны эхэд бичигдсэн “Тамачин” гэдэг нь дээр дурдсан “Тама” хэмээх цэргийн хүнийг, тухайлбал “Тама суух” үүрэг хүлээсэн хүнийг нэрлэж байсан нэр гэдэг нь илэрхий байна. Тамачин гэж тама цэрэгт томилогдсон хүмүүсийг, түүний дотор Тама цэргийн ноёныг бусад төрлийн цэргийн ноёдоос ялган тийн нэрлэж байж. Тиймээс МНТ-ны хятад хадмалд “Ноёны нэр” хэмээсэн буй за.

Харин “Тамгачин”-ы хувьд бол гол үүрэг нь “Эрх баригч, гааль татвар татварлах, тамга хадгалах” явдал учраас тэдэнд тийнхүү дайны фронтын тэргүүн шугаманд тулалдах, эртний цэргийн хэллэгээр “Хот харайх, цайз харайх” буюу хэрэм цайз өөд амь золин авирах гэж “Хуруу хумсаа хугачих” хэрэг гарахгүй нь ойлгомжтой.

“Тамгачин”-ы эл үүргээс улбаалан “Гааль, татварыг хэдийд хураан авдаг вэ?” хэмээх асуулт бас урган гарч ирнэ. Тэгвэл гааль, татварыг ямар нэг газар орон, улс аймгийг эрхшээлдээ оруулсан хойно л хураан авдаг. Эзлээгүй байж гааль, татвар хураана гэж юу байх билээ? Тэгэхээр тийм гол үүрэг бүхий ажилтай хүнийг хэдийд томилох вэ? гэвээс мөн л тухайн улс аймгийг дагаар оруулсан юмуу эсвэл хүчээр эзэлсэн хойно л томилно уу гэхээс биш, урьдчилж томилох нь юу л бол! Давтан өгүүлвээс “Гааль татвар татварлагч, тамга хадгалагч” ноён бол яав чиг нутаг орон, хот сууринг эзлэхээс өмнө томилогдож таарахгүй агаад гагцхүү хот цайзыг дайлах хатуу ширүүн байлдаан болоод өнгөрсөн хойно томилогддог учир тэдэнд

“Таван хуруудын химулыг (хумсыг) ину

Тамгартал

Давтмал хатанга балгадад авируулах¹⁰ үүрэг ногдуулахгүй нь логик талаасаа ч ойлгомжтой байна.

Нэгэн зүйл: Элдэндэй, Ардажав нар “Тамгачин”-ы үүргийг тодорхойлохдоо МНТ-ны 274-т “Тама сууж, шар алт, шармал алттан, нахуд, нажид, дардас, сувд, тана, хүзүү урт, хөл өндөр тобичагууд, хүрин эрүүгүүд, тууш гичид, ачаанаа (ачааны) хачид, луусуудыг он онд хүргүүлж,

9. Donald Ostrowski. The ‘tamma’ and Dual-Administrative Structure of the Mongol Empire.

Bulletin of School of Oriental and African Studies, University of London, Vol.61, No.2. (1998), pp. 262-277.

10. Чоймаа Ш. Монголын нууц товчоон. Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг. УБ, 2011.

илгээн адхун (байгтун)” хэмээв гэх мэт баримтыг эши үндэс болгож, “Тамачин”-тай ойролцоо бичлэг, дуудлагатай нь гагц “Тамгачин” гэдэг үг байх тул түүнийг сонгон өөрсдийн тэрхүү таамаглалыг дэвшүүлжээ.

Тамачины гүйцэтгэж асан үүргийн нэг нь энэ мөн. Гэхдээ гол үүрэг нь бус, харин хавсрага нэгэн үүрэг нь. Тиймээс “Тамачин-ы гүйцэтгэж байсан бусад үүрэг, бүтэц бүрэлдэхүүний онцлогийг харгалзахгүйгээр гагц түүнийг эши үндэс болгон “Тамгачин” болгох нь учир дутагдалтай юм.

Тэгвэл “Тама”, “Тамачин” гэх үгс хаанаас үүдэлтэй үг байж таарах вэ?

Эртний монгол цэргийн олон нэртомьёо одоо цагт мартагналлын мананд халхлагдан бүдгэрч одсоны нэгэн адил эл үгийг ч тэр бүр хүн мэдэхээ байж. Тэр тусмаа хэдийгээр судлаач эрдэмтэн боловч гадаадынхны хувьд бол утга учрыг нь ухахад бэрх хүндрэлтэй байх нь зүй. Тиймээс тэд монгол үгсийн сангаас “Тама” гэх үгийг хайж ядаад гаднаас бэдэрсээр дуудлага, бичлэг төстэй үг олсон нь дээр дуртгасан хятадын “Tan-ma”(探馬) хэмээх үг аж. Монголоос хайгсад нь мөн л ажил үүргийн хийгээд бичлэг, дуудлага төслөг ойроор нь “Тамгач” гэдэг үгийг олж.

Гэтэл “Тамгач” гэлтгүйгээр, “Тама”-тай язгуур нэг “Тамах” гэдэг үг байдгийг яагаад ч юм бэ хэн нь ч анзаараагүй байна.

Эрт цагт монголчууд ан гөрөө хийхдээ эхлээд авын газрыг алсуур бүслээд, зээглэн эгнэцгээж аажмаар урагшлан эгнээ жагсаалаа жигдхэн хумидаг байсан агаад тийнхүү давшилхийлэх үед заримдаа анчин гөрөөчдийн зээглэсэн эгнээ алдагдаж, зарим газарт булан тохой үүсч орхигдох нь цөөн бус тохиолддог байна. Тийнхүү “Авын орхигдсон, үлдсэн газрыг түргэвчлэн хураан авах, хумихыг тамах гэдэг¹¹ байж.

Монголчууд эрт цагаас ан авыг цэргийн байлдааны бэлтгэл сургуулийн чухал нэг хэсэг гэж үзсээр ирсэн, тэгээд ч байлдах дайлах олон арга нь ан авын аргаас үүдэлтэй байдаг. Тэдгээрийн нэг нь энэхүү “Тамах” арга зарчим. Тухайлбал, ямар нэг улс аймаг, газар орныг дайлан их цэрэг өргөн фронтоор давших үед эгээ л ан авын үеийнх шиг зарим нэг газар нутаг үлдэж хоцроод гэнэт ар тал, хажуу хавиргаас аюул учруулах үе бишгүй гардаг. Мөн туулан өнгөрсөн газар орныхон бослого тэмцэл гаргаж ар талд бужигнуулах нь ч энүүхэнд. Тиймээс дайны цагт тэрхүү аюулаас сэргийлж, урьд яваад өнгөрсөн газар орон бүрийг тандуулан сахиулах, үймээн самуун, дайсагналыг дарж, нэг ёсондоо ан авын эгнээг хамж тамаж тэгшилдэг шиг хэв журманд нь оруулах үүрэг бүхий тусгай цэрэг томилон гаргадаг байж. Тиймээс тийм цэргийг “Тама” цэрэг гэдэг байсныг Рашид ад-Дины тэмдэглэл ч дээр дурдсанчлан нотолж байгаа юм.

11. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. (Таван боть) IV (Т-Хө). УБ, 2008, т.1905.

Гучин зургаат тайлбар толь. Tomus I. Fasciculus 9. УБ, 1961.т.6.

“Тама” буюу “Тамачи” цэрэг ямар үүрэгтэй байв? хэмээвээс МНТ болон бусад сурвалжид өгүүлснийг нэгтгэн багцалваас:

- эн түрүүнд урьд нь монгол цэргийн дайрч өнгөрсөн болон эзэлсэн газар оронд хяналт тогтоон, тэдгээрт үймээн самуун гарахаас сэргийлэн тандалт ажиглалтыг тасралтгүй хийж, фронтын ар талыг найдвартай халхлан хамгаалах;

- дайн байлдаан ид явагдаж буй үед бол гол цэргийн ар хударгаар дайсны цэрэг дайран давшихаас сэргийлэх, үүний тулд болзошгүй дайсныхаа байр байдлыг байнга сайтар тагнаж байх;

- аль нэг газарт тамагдалгүй үлдсэн дайсан илэрвэл цаг алдалгүй түргэн шуурхай довтолж, тэдэнтэй шууд дайтан, тэдний оршин байгаа хэрэм цайз, бэхлэлтийг дайран эзлэх. Илт давуу хүчтэй тулгарсан нөхцөлд удирдлагадаа мэдэгдэж, гол хүчээ иртэл саатуулан барьж байх;

(Хэрвээ “Тама” цэрэг байгаагүйсэн бол аюул тулгарч буйг алс хол орших хааны ордонд мэдэгдэх, дайсныг даруулахаар их цэрэг дайчлан илгээх гэх мэтэд цаг их алдах байснаар барахгүй урьд нь эрхшээсэн улс аймгуудаа ч дайсандаа алдаж болзошгүй нөхцөл үүсэх байв);

- үймээн самуун, бослого тэмцэл гарвал түргэн шуурхай хүрэлцэн очиж, газар авахуулалгүй дарж, тогтсон дэг журам, засаг хууль, хэв журмыг чандлан сахиулах;

- шашин хоорондын болон үндэстэн, ястнуудын хооронд зөрчил тэмцэл гаргуулахгүй байх;

- Хаант төрийн санхүүг арвижуулах талаар байнга анхаарч, дээрээс тогтоосон хэм хэмжээний дагуу гааль, татвар, өр төлөөсийг цаг тухай бүрт нь саадгүй гаргуулах гэх мэт.

Тама цэрэг аль нэгэн хот сууринд байрладаггүй, ямагт гадна талд байрладаг байсан. Энэ нь нэгд: цэргийн аюулгүй байдлыг сахин хамгаалахтай холбоотой, тухайлбал хот суурингийн дотор байрлавал аюулд өртөх эрсдэл илүү байж болзошгүйтэй холбоотой; хоёрт: түргэн шуурхай хөдлөх нөхцлийг хангасан байршилтай байснаар өргөн дэлгэр газар оронд хяналт тогтоон, шаардлагатай үед, шаардлагатай газарт гэнэт хүрч очих боломж бүрдүүлэх зэрэг цэргийн бодлоготой ч холбоотой байв.

“Тама” буюу “Тамачи” цэргийн үүсэл, бүтэц бүрэлдэхүүний тухайд өгүүлвээс: Чингис хаан Алтан улсыг дайлж байсан их дайралдааны үед өрнө зүгт хил залган оршиж асан Сартаул улсын эзэн Мухаммед шах илтэд дайсагнасан бодлого явуулж, Их Монгол Улсын тусгаар тогтнолд шууд аюул занал учруулж эхэлсэн тул нэн даруй түүнийг номхтгон дарах шаардлага тулгарчээ. Гэтэл Алтан улс хийгээд Сартаул улсын аль алинаас нь хүн хүчний тоогоор үлэмж дутуу байсан монгол цэрэг хоёр фронтод

нэгэн зэрэг дайтах боломжгүй байсан тул Чингис хаан Алтан улсад хийж байсан дайныхаа өргөн цар хүрээтэй байлдааны ажиллагааг түр завсарлах шийдвэр гаргахад хүрчээ. Тэгэхдээ урьд хэдэн жилийн дотор эрхшээлдээ оруулаад байсан Алтан улсын газар нутгийг эзэнгүй орхиж болохгүй, нөгөө талаар монгол цэрэг өрнө зүгт дайлаар мордсон хойно ар хударгаар аюул учруулж болзошгүй тул харьцангуй цөөн тоотой ч, байлдааны хүчин чадавх сайтай цэргийг томилон Алтан улсад илгээх шаардлага тулгарсан байна. Тиймээс Чингис хаан 1217 онд Мухали-д Жалайр, Уругуд, Мангуд, Хонгирад, Ихирэс таван аймгийн харьяат нарын дотроос цэргийн эрдэм, бие шил сайтай эрсийг сонгон өгч тусгай замын цэрэг бүрдүүлж мордуулсан нь “Тама” буюу “Тамачи” цэргийн үүтгэл болсон гэдэг. Түүнээс инагш монгол хаад “Тамачи” цэргийг түгээмэл хэрэглэх болсон билээ. Жишээ нь, Өгэдэй хааны үед Чормахан хорчид тамачи цэрэг захируулан Перс рүү илгээж байсан ба Есүдэр ноёныг тамачи цэрэгтэй нь Солонгост суулгаж байсан гэх мэт мэдээ бий. Хубилай сэцэн хаан Юань гүрнийг байгуулсныхаа дараа тамачи цэргийн ангиудыг олноор байгуулж зүг зүгт илгээн суулгаж байв. Эл цэргийн анги, салбарууд нь тухай тухайн газар орон, хот балгадад суулгасан даргачин нарт туслах хамгийн ойрын бэлтгэл хүчин болж, Монголын их гүрний өнцөг булан бүрт хаант төрийн аюулгүй, энх амгалан байдлыг хангах баталгаа болж байжээ.

Тама цэрэг нь анхандаа дан монгол цэргээс бүрдэл болж байсан бол эзэнт гүрний хил хязгаар, газар нутаг тэлэхийн хэрээр яваандаа бусад улс аймгийн цэргүүдээс ч шилж сонгон илгээх болсон байна. Юань улсын үед олон замын тамачи цэргийн бүрэлдэхүүнд “Өнгөт нүдтэн” буюу одоогийн Дундад хийгээд Төв Азийн болон гадаадын бусад олон овог аймгийн цэрэг, зарим газарт итгэлийг олсон хятад, зүрчин цэрэг ч багтах болжээ.

Монголын их гүрний үед тама цэрэг нь стратегийн тодорхой чиглэл, хот суурин, газар нутгийг хариуцан нэгэн районд удаан хугацаагаар байрлах болсон бөгөөд чингэх үед зэр зэвсэг, хүнс хэрэглэлийн хангалт, ер нь бүхий л талаар тухай тухайн газар орноос үл хамаарах байдалтай байх шаардлага тулгарч байсан тул тама цэргийн анги салбар бүр өөрийн гэсэн бэлчээр нутаг, мал сүрэг, газар тариалан, зэвсгийн дархны газар, өөрөөр хэлбэл хүрэлцээтэй хэмжээний “Хангалтын бааз”-уудтай байдаг байсан байна.

Эцэст дээр өгүүлсэн бүгдийг нэгтгэн дүгнэхүй:

1. Монголын нууц товчоонд тэмдэглэгдсэн “Тама”, “Тамачин” гэдэг үгс ямар нэг гадаад үг бус, харин утга агуулгын болон дуудлага, хэлбэрийн хувьд ч ан авын үед хэрэглэж ирсэн “Тамах” хэмээх үгтэй нэг язгуур бүхий монгол үгс бөгөөд монгол цэргийн байлдах, дайлах олон арга ан аваас үүдэлтэй буюу холбоотой байдгийн адил зарчмын хувьд цэргийн хэрэгт

тэр л агуулга, хэлбэрээрээ шилжиж уламжлагдан хэрэглэгдэж байсан нэр томъёонууд байна;

2. “Тама” гэдэг нь нэгэн төрлийн тусгай баг цэргийн нэр ба “Тама талбих, тама суулгах” гэж тийм цэргийг томилохыг хэлсэн үг. “Тамачин” хэмээх нь “Тама” цэргийн ноёныг бусад төрлийн цэргийн ноёдоос ялган нэрлэсэн нэр. Тийм учир тэдгээрийг “Тамгач”, “Тамгачин” гэж хөрвүүлэх үндэсгүй байна. Тэгээд ч “Тамгач цэрэг” гэх нэр томъёо түүхийн ямар ч сударт тэмдэглэгдээгүй билээ;

3. Юань улсын түүхнээ “Тамачи” хэмээн тэмдэглэгдсэн цэрэг Чингис хааны үед болон Монголын их гүрний үед өрнө дахинд “Тама” гэх хэлбэрээр нэрлэгдсээр байжээ;

4. Чингис хааны анх үүсгэн байгуулсан тусгай зориулалтын “Тама” цэрэг нь түүний үе залгамчлагчдын үед ч тэр хэлбэр, зориулалтаараа оршин тогтнож, Монголын их гүрний үед монголчуудын эрхшээсэн газар бүрт аюулгүй байдлыг хангах, Их Засаг хуулиар тогтоосон хэв журмыг чанд сахиулан, олон улс даяар дайн тулааныг зогсоон “Монголын энх амгалан”-г тогтооход чухал үүрэг гүйцэтгэж байжээ.

5. Тама цэрэг нь үүрэг, зориулалтын хувьд ХХ зуунд АНУ-ын Зэвсэгт Хүчинд үүсгэн байгуулсан “Түргэн байрлуулах хүчин” болон бусад улсын ийм маягийн цэрэгтэй ижил байна. Энэ баримт бол шинэ үеийн тэрхүү “Түргэн байрлуулах хүчин” маягийн шуурхай, гавшгай цэргийг ашиглах зарчмыг монголчууд анхлан санаачилж, бүр XIII зуунд цэргийн хэрэгт хэрэглэж эхэлсэн болохыг харуулж байна хэмээн дүгнэх үндэстэй байна.

Abstract: In the 13th century, *Tamma* or *Tamachin soldier* had played a very important role within the military formations of the Great Mongol State. The sections 273, 274, 276, and 281 of the *Secret History of the Mongols* has well described the *Tamma soldier*. In connection with this, some researchers try to prove that the word *Tamma* comes from the Chinese word *Tan-ma* or has been originated from Kidan, Turkish or Tibetan languages. Others prove that this word comes from the Mongolian word *Tamgach* or *Tamgachin*. The author of this article considers the Mongolian word *Tamakh* (to deploy) the root of which is *Tamma*. Therefore, the *Tamma soldier* can be considered as medieval military unit similar to the modern “Rapid Deployment Force”, established within the US Army in the 20th century. Therefore, based on this fact, it concludes that Mongols had first pioneered the theory of the operative and speedy forces and implemented it in the warfare as early as the 13th century.